

АЙМГИЙН ЖЕНДЭРИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ОРОЛЦОО ЧАДАВХ

СЭДЭВ: “ЖЕНДЭРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ТӨРИЙН
БАЙГУУЛЛАГЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТӨД ТУСГАХ НЬ”
АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТ
Чойбалсан хот, Дорнод аймаг
2018 оны 12-р сарын 7-8-ны өдөр

*А.Нарантуяа, Дундговь аймгийн Нийгмийн
бодлогын хэлтсийн дарга*

АЙМГИЙН ЖЕНДЭРИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

ЗОРИЛГО:

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх, эмэгтэй, эрэгтэйчүүдийн эрх тэгш оролцоог хангах, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бүх түвшний бодлого, үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд оршино.



АЙМГИЙН ЖЕНДЭРИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

ЗОРИЛТ:

- ❖ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр төрийн албаны чадавхыг бэхжүүлэх
- ❖ Жендэрийн ойлголтыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах
- ❖ Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй бодлого хэрэгжүүлэх



АЙМГИЙН ЖЕНДЭРИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

ЗОРИЛТ:

- ❖ Иргэдийн хөдөлмөр эрхлэхэд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжих
- ❖ Хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
- ❖ Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр төрийн албаны чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд:

- ❖ Аймаг, сумын хөгжлийн бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр, төсөлд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэхэд сургах
- ❖ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах , хэрэгжилтийг зохион байгуулах талаар Бүх шатны Засаг даргын үр дүнгийн гэрээнд тусгах
- ❖ Аймаг, сумд жил бүр жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр төлөвлөгөөг боловсруулан батлуулах, хэрэгжүүлэх




ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ОРОЛЦОО

- ❖ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх, арга зүйн дэмжлэг үзүүлэх
- ❖ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, гарсан зөвлөмжийг бодлого төлөвлөлтөд тусгах
- ❖ Төрийн албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх чиглэлээр сургалтыг зохион байгуулах, сургагч багш бэлтгэх



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ОРОЛЦОО

- ❖ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үр дүнтэй ажилласан ААН, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагааг сурталчлах, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, урамшуулах
 - ❖ Салбар, орон нутгийн хэмжээнд хүйсээр ангилсан статистик мэдээлэлтэй болох, дүн шинжилгээ хийдэг байх
 - ❖ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр гарын авлага материалтай болж, сургалт тогтмол зохион байгуулах
- 

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ОРОЛЦОО

- ❖ Төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл аймаг, сумын ЗДТГ-ын хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх
- ❖ Төрийн болон төсөв байгууллагын нийт ажилчдын дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хүний нөөцийн төлөвлөлтөд тусгаж хэрэгжүүлэх /Хөдөлмөрийн тухай хуулийн 101.1 дэх заалтыг хэрэгжүүлэх болон сургуулийн өмнөх боловсролын байгууллага зэрэг байгууллагын ажил, үйлчилгээний онцлогоос хамаарч нэг хүйсийн хүнийг сонгох асуудал үл хамаарна./

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Жендэрийн ойлголтыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд:

- ❖ Орон нутгийн хэмжээнд жендэрийн тэгш байдлын асуудлаар судалгаа хийж, тулгамдсан асуудлаа тодорхойлох
- ❖ Жендэрийн талаарх шаталсан сургалтыг бүх шатны Засаг дарга, ИТХ-ын дарга, бүх байгууллага, ААН-ийн удирдлагууд, холбогдох ажилтнуудын оролцуулан тогтмол зохион байгуулах
- ❖ Эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг бий болгох



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ОРОЛЦОО

- ❖ Эрэгтэйчүүдийн өвчлөл, нас баралтын байдал, түүнд нөлөөлж байгаа эрсдэлт зан үйлийг өөрчлөх, эрүүл зан үйл, аж төрөх хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх
- ❖ Жил бүр хүйсээр ангилсан мэдээ, мэдээлэл бүхий жендэрийн мэдээлэл эмхтгэл гаргаж, онлайнаар болон хэвлэж олон нийтэд хүргэх
- ❖ Жендэрийн асудлаар бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх нөлөөлөл, гэгээрэл сурталчилгааны ажлыг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй бодлого хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

- ❖ Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дунд зонхилон тохиолдож байгаа нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа өвчлөлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах
- ❖ Эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тасаг, кабинетыг ажиллуулж, хүний нөөц, техник тоног төхөөрөмжөөр хангах
- ❖ Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ОРОЛЦОО

- ❖ Эрүүл мэнд, нөхөн үржихүй, ялангуяа бэлгийн боловсрол олгох сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрөөр заадаг болох
- ❖ Эрүүл амьдралын зан үйлд суралцаж хорт, буруу зуршлаас ангижрах арга ухааныг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг тасралтгүй явуулах
- ❖ Эрүүл амьдралын зан үйл, дадал эзэмшсэн эрэгтэйчүүдийн ололт, амжилтыг олон нийтэд сурталчилах



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Иргэдийн хөдөлмөр эрхлэхэд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжих:

- ❖ Иргэнийг ажилд авахдаа тухайн байгууллага болон түүний бүтцийн нэгж дэх хүйсийн төлөөллийн тэнцвэртэй байдлыг харгалзан цөөн тоотой хүйсийн хүнийг сонгох
- ❖ Хөдөлмөрийн дотоод журамд ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах талаар тусгах
- ❖ Өрх тэргүүлсэн олон хүүхэдтэй, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой эцэг, эхчүүдийг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх:

- ❖ Хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Хүний эрхийн үндэсний комисс болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөлтэй хамтран ажиллах
- ❖ Охид эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх
- ❖ Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран сурталчлах
- ❖ Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах байрны үйл ажиллагааг тогтмолжуулж, санхүүжилтын дэмжлэг үзүүлэх
- ❖ Өсвөр үе, залуучуудын дунд гэр бүлийн үнэт зүйлсийн талаарх ойлголт, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг эцгээх, олон нийтийн оролцоонд тулгуурлан зохион байгуулах

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх:

- ❖ Улс төрийн болон төрийн захиргааны удирдах албан тушаалд эмэгтэй, эрэгтэй хүнийг санал болгох, нэр дэвшүүлэх, өрсөлдөх шалгуурыг тогтоож, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан квотыг хэрэгжүүлэх
- ❖ Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд ажиллахад бэлтгэх, чадавхжуулах, манлайллыг бий болгох чиглэлээр эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагатай хамтран ажиллах



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХ

- ❖ Хууль эрх зүйн актууд:
 - **ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬ**
 - **ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**
 - **ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР**
- ❖ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар зөвлөл, түүний гишүүд
- ❖ Жендэр хариуцсан мэргэжилтэн /АЗДТГ-ын НБХ/
- ❖ Төрийн бүх байгууллагын оролцоо
- ❖ Мэргэшсэн сургагч багш нар
- ❖ Төрийн албан хаагчид



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

